



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 04 сарын 19 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

“16.2.1. татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орох төсвийн орлогыг дараах хувиар тооцно:

16.2.1.а. нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай үед 50 хувиар тооцсон орлого;

16.2.1.б. нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай үед 100 хувиар тооцсон орлого.”

2 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3 дахь заалтын “болон эрсдэлийн сангийн” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний баялгийн сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР